



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/309

Эрдэнэбулган сум

“Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Архангай аймагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Архангай аймагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Архангай аймагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Р.Гандиймаа/-д даалгасугай.

3. “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Архангай аймагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сумынхаа онцлог хэрэгцээнд тохирсон төлөвлөгөөг батлан шаардагдах санхүүжилтийг сумын болон эрүүл мэндийн байгууллагын жил бүрийн төсөвт тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Архангай аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, сумдын Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёл урлагийн газар, Цагдаагийн газар, Биеийн тамир спортын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар, хэвлэл, мэдээллийн байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дарга нарт даалгасугай.

5. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутам аймгийн Эрүүл мэндийн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга, холбогдох байгууллагуудын дарга нарт даалгасугай.

ОРЛОГЧ

Б.БОЛОРМАА



651811009

Аймгийн Засаг даргын 2018 оны
06 сарын 27-ны өдрийн 1302 дугаар
захирамжийн хавсралт



**“ХАЛДВАРТ БУС ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ АРХАНГАЙ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2021 ОН/**

Зорилго		“Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олон, нийгмийн олон талт хамтын ажиллагаанд тулгуурлан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах”				
Үр нөлөө /үр нөлөөний шалгуур үзүүлэлт/	№	Шалгуур үзүүлэлт		Суурь үзүүлэлт 2017 он	2019 он	2021 он
		1	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт /10000 хүн амд/	2.7	11,6	10,5
		2	Зүрх судасны тогтолцооны нас баралт /10000 хүн амд/	17.1	17,6	17,4
		3	Бөөрний сувганцарын үрэвсэлт өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч, хувиар	47.6	46.5	45.5
№	Үйл ажиллагааны чиглэл	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага	Хугацаа
Зорилт 1: Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчинг бүрдүүлэх замаар халдварт бус өвчинд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах						
1.1.	Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн чанар, үр дүнг сайжруулах	1. Эрүүл мэндийн хичээлийн багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан багш нарын тоо	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2019
		2. Эрүүл мэндийн хичээлийн чанар, үр дүнд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх	Үнэлгээний тайлан, зөвлөмж	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2020
		3. Эрүүл мэндийн хичээлийн олимпиадыг жил бүр зохион байгуулах	Олимпиадад оролцсон хүүхдийн тоо	ЭМГ, БСУГ	Аймгийн ЗДТГ, ЕБС-иуд	2018-2021
1.2	Сурагчдын эрүүл мэндийн байдлыг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх	1. Сургуулийн эмч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан эмч нарын тоо	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2019
		2. Сурагчдын эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад багшийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх уулзалт зохион байгуулах	Уулзалтанд оролцсон сургуулийн тоо	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2018-2019
		3. Сургуулийн эмч нарын ажлын байранд үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангах	Үнэлгээний дүн, зөвлөмж	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2019-2020

		4. Сурагчдын эрүүл мэндийн үзүүлэлт тогтоох, бүртгэх, мэдээлэх, мэдээний цахим сан үүсгэх, ашиглах журам боловсруулж, ашиглах	Үүсгэсэн цахим сан, ашиглалтын тайлан	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2019
1.3	Тамхи, архи, халдварт бус өвчний бусад эрсдэлт хүчин зүйл, сэтгэцийн эрүүл мэндийн талаар ухуулга, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	1.Төр, хувийн хэвшлийн байгууллагын удирдлага, ажилтнуудад сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан байгууллагын тоо	Аймгийн ЗДТГ, ЭМГ, ЦГ	Бусад байгуул лагууд	2019-2020
		2. Хүн амын зан үйлийн буруу зуршил, зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт, сурталчилгааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран зохион байгуулах	Гэрээ хийсэн хэвлэл, мэдээллийн байгууллагын тоо	ЭМГ	Хэвлэл, мэдээллийн байгуул лагууд	2018-2021
		3. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, өвчтөн, биеийн тамирын аргазүйчийн мэдлэг, хандлагыг өөрчлөх гарын авлага хийж, сургалт хийх	Сургагдсан хүний тоо	ЭМГ	ЭМБ-ууд	2019-2021
1.4	Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын донтолтоос урьдчилан сэргийлэх	1. Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын донтолтоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг сурагч, өсвөр үеийнхний дунд зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан сурагч, өсвөр үеийнхний тоо	ЭМГ, БСУГ	ЕБС-иуд	2019-2021
		2. Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын донтолтын хор уршигын талаар иргэдэд зориулсан зөвлөгөө, мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэх	Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээллийн тоо	ЭМГ	Хэвлэл, мэдээллийн байгууллагууд	2019-2021
1.5	Тамхи, архи, согтууруулах ундааны хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	1. Тамхи, архи, согтууруулах ундааны хуулийг олон нийт, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан байгууллагын тоо	Аймгийн ЗДТГын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар	Сумдын ЗДТГ	2018-2021
		2. Тамхи, архи, согтууруулах ундааны хуулийн хэрэгжилтэнд хийх хяналт, үнэлгээг тогтмолжуулж, зөвлөмжөөр хангах	Үнэлгээний дүн, өгсөн зөвлөмж	Аймгийн ЗДТГын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар	Сумдын ЗДТГ	2018-2021

		3. Орон нутгийн Засаг даргын шийдвэрээр архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудын үйлчилгээний цагт хязгаарлалт тогтоох	Хязгаарлалт тогтоосон шийдвэр	Аймаг, сумдын ЗДТГ	ЦГ	2018-2021
1.6	Архи, тамхи, бусад донтох эмгэгээс гарах, хордлого тайлах, эмчлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	1. Архи, тамхи, бусад донтох эмгэгээс гарах, хордлого тайлах эмчилгээний стандартын хэрэгжилтийг сайжруулах сургалт хийх	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо	ЭМГ	ЭМБ-ууд	2019-2021
		2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарыг "Архи, тамхинаас гарах хүсэл төрүүлэх, хорт зуршлыг хаях зан үйлийг төлөвшүүлэх" талаар зөвлөгөө өгөх, сургалт хийх аргазүйгээр хангах	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо	ЭМГ	ЭМБ-ууд	2019
		3. Архинаас сайн дураараа татгалзсан иргэдийн "Булганхангай" клубын үйл ажиллагааг өргөжүүлэх, олон нийтэд сурталчлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	Аймгийн ЗДТГ, ЭМГ, ЦГ	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгуул-лагууд	2018-2021
1.7	Давсны хэрэглээний тандалт, судалгаа хийх	1. Эрүүл мэндийн байгууллагуудыг шээсэнд натри тодорхойлох багаж, аппаратаар хангах	Багажаар хангагдсан ЭМБ-ын тоо	ЭМГ	ЭМБ-ууд	2020
		2. Эрүүл мэндийн байгууллагуудыг хоол, хүнсэн дэх давс, натрийн агууламжийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээний тест, багажаар хангах	Багажаар хангагдсан ЭМБ-ын тоо	ЭМБ-ууд	Аймгийн ЗДТГ, ХХААГ	2019-2020
		3. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэнд хүн амд давсны зохистой хэрэглээний зөвлөгөө өгөх чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан ЭМБ-ын тоо	ЭМГ	ЭМБ-ууд	2019-2020
		4. Цусны даралт ихсэлт, хавдар, зүрх судасны өвчний улмаас эмчид хандаж буй хүний натрийн агууламжийг тодорхойлж, зөвлөгөө өгөх	Натрийн агууламж тодорхойлуулсан хүний тоо	ЭМБ-ууд	ЭМГ	2020-2021
		5. Эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсад болон үйлчлэх хүрээний хүн амын давсны хэрэглээг тандах үзлэг, шинжилгээг жил бүр зохион байгуулж,	Бүрдүүлсэн мэдээллийн сан	ЭМГ, ЭМБ-ууд	Байгуул лагууд	2019-2021

		мэдээллийн сан бүрдүүлэх				
		6. Давсны талаар олон нийтэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн арга хэмжээг жил бүр зохион байгуулах	Давсны зохистой хэрэглээний талаар мэдлэгтэй хүн амын хувь	ЭМГ, ЭМБ-ууд	ХХААГ, МХГ, Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	2018-2021
1.8	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд стрептококкийн халдварын тархалтыг тандах	1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд стрептококкийн халдварын тархалтыг судлах	Судалгааны дүн	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2020
		2. Хэрх өвчний эмнэлзүйн удирдамжийн талаар анхан шатны ЭМБ-уудын эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх	Сургалтанд хамрагдсан эмч нарын тоо	ЭМГ	-	2019
		3. Ерөнхий боловсролын сургуулиуд дээр Хэрх өвчний гаралтай зүрхний өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, тархалтыг бууруулах	МСС-д хамрагдсан сургуулийн тоо	Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн ЭМТ	ЭМГ, БСУГ	2019-2020
1.9	Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнтэй ажиллаж буй иргэн, хамт олон, байгууллагын үйл ажиллагааг дэмжих	1. Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа, тэмцээн уралдааныг зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, төрөл	БТСГ, АШЭМБ	ЭМГ	2019-2021
		2. Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийг хүний илүүдэл өөх, уураг, нүүрс ус, бие физиологийн зохицолдоо, таргалалтыг хянах тоног төхөөрөмжөөр хангаж, судалгаа, шинжилгээнд ашиглах	Хангагдсан тоног төхөөрөмж	ЭМГ	ЭМЯ	2020
		3. Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшинг тогтоож, түвшинг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулах	Үнэлгээний дүн	БТСГ, ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2018-2021
		4. Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхээр үр дүнтэй ажиллаж байгаа иргэн, хамт олон, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, урамшуулах, олон нийтэд сурталчлах	Дэмжиж урамшуулсан байгууллагын тоо	БТСГ, АШЭМБ	ЭМГ	2018-2021
1.10	Сургуулийн сурагчдын архаг халдварын голомтыг эрт	1. Амны хөндийн эрүүл мэндийн талаар сурагчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Мэдлэгийг дээшлүүлсэн сурагчдын тоо	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2018-2021

	илрүүлэх, эмчлэх, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авах	2. Сургуулийн сурагчдын шүдний өвчлөлийг илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх	Үзлэг, эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	ЭМБ-ууд БСУГ	ЭМГ	2018-2021
		3. Цэцэрлэг, сургуулийг түшиглэн хүүхдийн сул хараа, харааны гажгийг илрүүлэх үзлэгийг 3, 6, 14 настайд тогтмол хийж, бүртгэх, мэдээлэх, хүүхдүүдийг хяналтанд авч харааг засах	Үзлэгийн мэдээ	Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн ЭМТ	ЭМГ, БСУГ	2018-2021
		4. Сурагчдын өсөлт, хөгжилтийн хоцрогдол, илүүдэл жин, таргалалтыг тандах, бүртгэх, хянах, мэдээлэх журам батлан хэрэгжүүлэх	Боловсруулсан журам	БТСГ, ЭМГ	БСУГ, ЭМБ-ууд	2019-2021
		5. Сургуулийн эмч, нийгмийн ажилтан, биеийн тамирын багш, эрүүл мэндийн хичээлийн багш нарт илүүдэл жин, таргалалттай хүүхэд, эцэг, эхчүүдэд хоол, хөдөлгөөний зөвлөгөө өгөх үр чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан хүний тоо	БСУГ	ЭМГ	2019-2021
		6. ЕБС-ийн хүүхдийн бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох үнэлгээ, дүгнэлтийг жил бүр хийж, түвшинг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулах	Үнэлгээний дүн	БСУГ, БТСГ	ЭМГ, АШЭМБ-ууд	2018-2019
		7. Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах, сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, оношилох, эмчлэх, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн тоо	БСУГ, ГБХЗХГ, ЭМГ	ЭМБ-ууд	2019-2021
		8. Бөөрний үрэвсэлт өвчний тархалтыг бууруулах зорилгоор сургуулийн ариун цэврийн байгууламжийн хүртээмж /стандарт/-ийг сайжруулах	Ариун цэврийн байгууламжийг сайжруулсан сургуулийн тоо	БСУГ	Орон нутгийн ЗДТГ, ТББ, ОУБ	2019-2021
		1.11	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд	1. Иргэдийг цусны даралт, глюкоз, биеийн жингээ өөрсдөө хянах аргад сургах сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан байгууллага, хүний тоо	ЭМБ-ууд
2. Хөхний болон умайн хүзүүний өмөн, цусны даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлгийн хамрагдалт хангалтгүй	Судалгааны дүгнэлт			ЭМГ	АШЭМБ-ууд	2019

	иргэд, зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	байгаа шалтгааныг тогтоох судалгаа хийх 3. Ходоод, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл, мэдээлэл, хяналтыг хийх	Хорт хавдрын мэдээ	ЭМБ-ууд	ЭМГ	2018-2021
1.12	Зонхилон тохиолдох ХБӨ-ний нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах	1. Хүн амын суурьшлын газар дахь шарилж, хөл газрын ургамлыг 6, 7, 8 сард тайралт хийж, ургамлын тооцонцорын сөрөг үр дагаврыг бууруулах	Засаг дарга нарын захирамж	Сумдын ЗДТГ	Сум, өрхийн ЭМТ-үүд, байгуул лагууд	2018-2021
		2. Нийтийн хоолны газрууд, аялал, жуулчлалын баазуудад зохистой хооллолтын зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавих	Зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо	ЭМГ	МХГ, ХХААГ, БОАЖГ, сумын ЭМТ	2018-2019
1.13	Ажлын байрны болон мэргэжлийн таагүй нөлөөллөөс үүдэлтэй ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хамт олон, байгууллагын оролцоог идэвхжүүлэх	1. Байгууллагуудын ажиллагсдын эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан байгууллагын тоо	ЭМГ, ЭМБ-ууд	Байгуул-лагууд	2018-2021
		2. Байгууллагуудын ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, өвчтэй илрэгсдийг эмчлэн эрүүлжүүлэхэд байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байгууллагын тоо	ЭМБ-ууд	Төрийн болон хувийн хэвшлийн байгуул-лагууд	2018-2021
		3. Ажлын байрны эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх уралдаан, өдөрлөг, үзэсгэлэн, үзүүлэх сургууль зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	ЭМГ, ЭМБ-ууд	Төрийн болон хувийн хэвшлийн байгуул-лагууд	2018-2021
		4. Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургууль, ажлын байр, сум, баг болох хөдөлгөөн өрнүүлэх	Захирамж, шийдвэр	Аймаг, сумын ЗДТГ, БСУГ, ЭМГ	Албан байгуул-лагууд	2019-2021
Зорилт 2: Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил болон эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын оролцоонд түшиглэн бэхжүүлж, Халдварт бус өвчтэй иргэнийг эмчийн хяналтанд эрт авч, өвчлөл, нас баралтын тоог бууруулах нөхцөл бүрдүүлэх						
2.1	Хүний амьдралын нас, хүйс, мөчлөг бүрийн онцлогт тохирсон эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд	1. 40-65 насны иргэдийг жил бүр цусны даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулж, хяналтанд орсон иргэдийн мэдээллийн сан үүсгэж, эмчилгээнд хамруулах	Үзлэгийн хамрагдалтын хувь	Нэгдсэн эмнэлэг, Анхан шатны эрүүл мэндийн байгуул-лагууд	Албан байгуул лагууд	2018-2021
		2. 30-60 насны эмэгтэйчүүдийг товлот хугацаанд нь умайн хүзүүний эсийн	Үзлэгийн хамрагдалтын хувь	Нэгдсэн эмнэлэг,	Албан байгуул лагууд	2018-2021

	хамруулж, хяналтанд орсон иргэдийг бүртгэх, мэдээлэх нэгдсэн мэдээллийн сан үүсгэх	шинжилгээ болон хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамруулж, хяналтанд орсон иргэдийн мэдээллийн сан үүсгэх		АШЭМБ		
		3. Элэгний хавдрын эрсдэлт бүлгийн иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, мэдээллийн сан үүсгэх	Үзлэгийн хамрагдалтын хувь	Нэгдсэн эмнэлэг, АШЭМБ	ЭМГ	2018-2021
		4. Бөөрний өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд зорилтот насны иргэдийг хамруулж, хяналтанд орсон иргэдийн мэдээллийн сан үүсгэх	Үзлэгийн хамрагдалтын хувь	Нэгдсэн эмнэлэг, АШЭМБ	Албан байгууллагууд	2019-2021
		1. Халдварт бус өвчний эмнэлзүйн удирдамжийн хүрээнд холбогдох эмч, мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг	ЭМБ-ууд	2018-2021
		2. Анхан шатны ЭМБ-уудын эмч нарыг ЭХО-ны баримжаа олгох сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо	АШЭМБ-ууд	ЭМГ	2019-2021
		3. Нэгдсэн эмнэлгийн зүрх судасны эмч нарыг чадавхжуулан анхан шатны ЭМБ-уудын эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг	Сум, өрхийн ЭМТ-үүд	2019-2020
		4. Дотрын эмч нарыг ревматологийн сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2019 он
		5. Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн эмчийг умайн хүзүүний дуран, хөлдөөх болон LEEP эмчилгээ хийх арга барилд сургах	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2019-2020
		6. Нэгдсэн эмнэлгийн ЭХО, рентген, дурангийн эмч нарыг чадавхжуулах багийн сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2019-2020
		7. Сум, өрхийн эмч нарт Халдварт бус өвчний хүндрэлийг сэргээн засах тусламж, үйлчилгээний талаар сургалт явуулах	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ, Сум, өрхийн ЭМТ	2019
2.2	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, эмчлэх, хянах ажлыг эрхэлдэг эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх					
2.3	Эрүүл мэндийн анхан шатны	1. Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай	Үнэлгээний тайлан	ЭМГ	ЭМБ-ууд	2019

	тусламжинд ДЭМБ-ын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцыг нэвтрүүлж, хүн амд зөвлөгөө өгөх арга хэмжээг өргөжүүлэх	тусламж, үйлчилгээний багцын эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байдалд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх				
		2. Автомат даралт хэмжигч аппарат, иргэдэд зориулсан зөвлөмжийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд болон бусад байгууллагуудын ажлын байранд байрлуулах	Аппараттай болсон ЭМБ, бусад байгууллагын тоо	ЭМГ, ЭМБ-ууд	Нийт байгууллагууд	2019-2021
		3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг "Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц"-ыг хэрэгжүүлэх сургалтанд хамруулах	Сургалтанд хамруулсан байгууллагын тоо	ЭМГ	АШЭМБ-ууд	2019-2020
2.4	Зонхилон тохиолдох элэгний, ходоодны хорт хавдрыг эрт илрүүлэх, эмчлэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх	1. Элэгний хорт хавдар, ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл мэдээллийг сайжруулах	Эрт илрүүлгийн хувь	ЭМБ-ууд	ЭМГ	2019-2020
		2. Элэгний хорт хавдар, ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг, эмчилгээнд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг сайжруулах	Хангамжийн хувь	ЭМГ, ЭМБ-ууд	ЭМЯ	2019-2021
		3. Хорт хавдрын хими эмчилгээг орон нутагт хийх бокс өрөөг байгуулж, эмчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2019
2.5	Уушигны архаг бөглөрөлт өвчин, бөөрний үрэвсэлт өвчлөлийг эрт илрүүлэх, хяналтанд авах, иргэдийн урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг сайжруулах, зөвлөгөө өгөх ажлын чанах,	1. Уушигны архаг бөглөрөлт өвчний эрт илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, хянах тогтолцоог бүрдүүлж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх	Бүртгэл, мэдээллийн тайлан	ЭМБ-ууд	ЭМГ	2019-2020
		2. Бөөрний үрэвсэлт өвчлөлийг эрт илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, хянах тогтолцоо бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх	Бүртгэл, мэдээллийн тайлан	ЭМБ-ууд	ЭМГ	2019-2020
		3. Иргэдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг сайжруулах мэдээлэл, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	Сургалт сурталчилгаанд хамрагдсан хүний тоо	ЭМБ-ууд	ЭМГ	2018-2021

	хүртээмжийг сайжруулах	4. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн түвшинд "Тулгуур хөдөлгөөний өвчин"-ийг эрт илрүүлэх	Ясны сийрэгжилт, үений үрэвсэлтэй иргэдийн тоо	Сум, өрхийн ЭМТ	ЭМГ	2019-2020
2.6	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	1. Нэгдсэн эмнэлгийн дотор, хавдар, эмэгтэйчүүд, мэс заслын эмч, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн эмч нарт хөнгөвчлөх тусламж үйлчилгээний суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан эмч нарын тоо	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2019
		2. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтний хамтарсан хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлдэг баг байгуулах	Байгуулагдсан баг	Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ	ЭМГ	2020
		3. Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд шаардлагатай хямд үнэтэй, хурдан үйлчилгээтэй, уухаар хэрэглэдэг морфины хангамж, тасралтгүй байдлыг хангах	Эмийн хангамжийн хувь	ЭМГ	Нэгдсэн эмнэлэг	2019-2021
		4. Хөнгөвчлөх эмчилгээний талаар гэр бүл, олон нийтийн мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэх гарын авлага, зөвлөмж гаргаж сургалт, сурталчилгаа явуулах	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүн	Нэгдсэн эмнэлэг, АШЭМБ	ЭМГ	2019-2020

Зорилт 3: Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, Халдварт бус өвчний бүртгэл, мэдээлэл, тандалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим, нээлттэй тогтолцоог орон нутаг, бусад салбар, үндэсний хэмжээнд бий болгож бэхжүүлэх

3.1	Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоон шийдвэр гаргалтанд ашиглах	1. Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2019-2021
		2. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2019
		3. Хоол тэжээлийн судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2021
		4. Сахарын хэрэглээг тогтоох судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2021
		5. Архины хэрэглээ, эрсдэлт хүчин зүйл, шалтгаан эмгэгийг тогтоох судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	Цагдаагийн газар	2021
		6. Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2019
		7. Сэтгэл гутрал, уур бухимдал, амиа	Судалгааны тайлан	ЭМГ, ЭМБ-ууд	БСУГ	2019

		хорлолтын шалтгаан, нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлд судалгаа хийх				
3.2	Хүн суурилсан өвчлөлийн статистик мэдээлэл, Халдварт өвчний эрсдлийн хяналт, хариуцлага, мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх	амд 1. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын нэгдсэн мэдээний цахим сантай болох	Мэдээний сан	ЭМГ	ЭМБ-ууд	2019-2020
		бус 2. Халдварт бус өвчний хяналт, тандалтын нэгж байгуулах	Хяналт, тандалтын нэгж	ЭМГ	-	2020
		3. Халдварт бус өвчний эрсдлийг бууруулахад холбогдох байгууллагуудыг үүрэгжүүлэх	Үүрэгжүүлсэн эрхзүйн баримт бичиг	Аймгийн ЗДТГ	ЭМГ	2019

Зорилт 4: Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянахад үндэсний болон орон нутгийн байгууллагын чадамж, манлайлал, засаглал болон нийгмийн бусад салбар, олон улсын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах

4.1	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах асуудлыг нийгмийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх	1. Халдварт бус өвчний нийтлэг болон нийгмийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах асуудлыг нийгмийн салбарууд, орон нутгийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	Тусгагдсан асуудлын тоо	Аймгийн ЗДТГ	ЭМГ	2019-2021
		2. Аймаг, сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах асуудлыг тусгаж, үр дүнг тооцох	Тайлан	ЭМГ	Аймгийн ЗДТГ	2019-2020
		3. Ядуу, эмзэг бүлгийн иргэд, гэр бүлд Халдварт бус өвчин, түүний эрсдэлээс сэргийлэх хамт олонд суурилсан интервенци хэрэгжүүлэх	Нэвтрүүлсэн интервенци	ЭМГ, ЭМБ-ууд	Аймаг, сумын ЗДТГ, ХХҮГ	2020
4.2	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд ААНБ, ТББ-ын	1. "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа байгууллага, иргэдийг мэргэжил арга зүйгээр ханган дэмжиж ажиллах	Нэгжийн тоо	ЭМГ, ЭМБ-ууд	Аймаг, сумын ЗДТГ	2019-2021
		2. "Архигүй байгууллага, хамт олон" болох болзолт уралдаан зарлаж, дүгнэх, урамшуулах	Хамрагдсан байгууллагын тоо	ЭМГ, Цагдаагийн газар	Аймаг, сумын ЗДТГ	2019-2021

оролцоог өргөжүүлэх, ажлын үр дүн, оролцоог дэмжих	3. Архины хамаарлаас гарах эмчилгээ хийлгэсэн, гарахыг хүссэн хүн, тэдний гэр бүлийн хүмүүст туслах сайн дурын клуб, ТББ-д арга зүйн дэмжлэг үзүүлэх	Хамрагдсан байгууллагын тоо	ЭМГ, ЦГ, Нэгдсэн эмнэлэг	Аймаг, сумын ЗДТГ, АШЭМБ	2019-2021
	4. Архинаас татгалзсан залуучуудын чуулганыг 2 жил тутам хийж, үйл ажиллагааг нь иргэдэд сурталчлах	Чуулганы тайлан	Цагдаагийн газар, ЭМГ	Аймаг, сумын ЗДТГ	2020

---o0o---